



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA



Insightful
Innovative
Strategic

САНХҮҮГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХЭМЖИХ СУУРЬ СУДАЛГАА

2024

Захиалагч: Санхүүгийн зохицуулах хороо

Гүйцэтгэгч: Эм Эм Си Жи ХХК

Улаанбаатар

АГУУЛГА

ХУРААНГУЙ ҮР ДҮН.....	5
I. УДИРТГАЛ	7
II. БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА	8
III. СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН.....	14
3.1. Санхүүгийн эрүүл мэндийн индекс (Financial Health Index-FHI)	14
3.2. Нөөцийн/сангийн хүртээмж (Access-to-funds).....	17
3.3. Санхүүгийн хүртээмж (Access-to-finance)	19
3.4. Санхүүгийн зан төлөв (Financial behavior).....	21
3.5. Санхүүгийн төлөв байдал	27
3.6. Санхүүгийн мэдлэг.....	30
3.7. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	32
IV. ДҮГНЭЛТ	33
V. САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	35

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Санхүүгийн эрүүл мэндийн бүрдэл хэсгүүд	15
Зураг 2. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, бүрдэл хэсгүүдээр	16
Зураг 3. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, бүсээр	17
Зураг 4. 1 сарын дотор 895,000 төгрөг олох санхүүгийн эх үүсвэр.....	19
Зураг 5. 895,000 төгрөгийг 1 сар болон 1 долоо хоногийн дотор олоход хэр хэцүү байх байдал	19
Зураг 6. Банканд данстай эсэх.....	20
Зураг 7. Хадгаламжтай эсэх.....	20
Зураг 8. Банканд дансгүй байгаа шалтгаанууд, n=12.....	21
Зураг 9. Төлбөр тооцоо хийхдээ тогтмол ашигладаг хэрэгсэл	21
Зураг 10. Мөнгө зээлэх эх үүсвэр, хэлбэрээр.....	22
Зураг 11. Зээлийн хандлагын үзүүлэлтүүд	23
Зураг 12. Орлогынхоо зарим хэсгийг ирээдүйдээ зориулж хадгалдаг байдал	23
Зураг 13. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд өрхийн орлого, зарлагаа тодорхойлох байдал	24
Зураг 14. Орлогоосоо их зарцуулсан зөрүүгээ нөхсөн байдал	24
Зураг 15. Мөнгөө хадгалах хандлагын үзүүлэлтүүд	25
Зураг 16. Санхүүгээ (орлого, зарлага) төлөвлөдөг байдал	26
Зураг 17. Санхүүгээ төлөвлөж буй хугацаа	26
Зураг 18. Тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэдэг эсэх	26
Зураг 19. Зарцуулалтын хандлагын үзүүлэлтүүд	27
Зураг 20. Санхүүгийн хувьд бие даасан байдлын талаарх үзүүлэлтүүд.....	28
Зураг 21. Орлогын тогтвортой, найдвартай эх үүсвэртэй эсэх	29
Зураг 22. Өрхийн орлогын сар бүрийн өөрчлөлтийг тодорхойлж буй байдал.....	29
Зураг 23. Ирэх сарын өрхийн орлогын хэмжээг таамаглаж чадаж буй байдал.....	30
Зураг 24. Дор хаяж 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй эсэх	30
Зураг 25. Хөрөнгө оруулалт хийж буй хэлбэрүүд.....	31
Зураг 26. Санхүүгийн боловсрол авах суваг.....	32
Зураг 27. Санхүүгийн мэдлэгийн талаарх асуултуудад зөв хариулсан байдал.....	32
Зураг 28. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	33
Хүснэгт 1. Санхүүгийн эрүүл мэндийн тодорхойлолтууд	8
Хүснэгт 2. “Санхүүгийн эрүүл мэндийг хэмжих суурь судалгаа”-ны олон улсад судлагдсан байдлын жагсаалт	11
Хүснэгт 3. Санхүүгийн эрүүл мэндийн индексийн ангилал	15
Хүснэгт 4. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, дэд бүрдэл хэсгүүдээр.....	16
Хүснэгт 5. Санхүүгийн мэдлэгийн асуултуудад зөв хариулсан байдал	31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

₮	Монгол төгрөг
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББС	Баримт бичгийн судалгаа
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
МУ	Монгол Улс
ОУБ	Олон улсын байгууллага
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ҮНБ	Үндэсний нийт бүтээгдэхүүн
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
САPI	Computer Assisted Personal Interview
САTI	Computer Assisted Telephone Interview
САWI	Computer Assisted Web Interview
CFI	Center for Financial Inclusion
FHI	Financial Health Index
FHN	Financial Health Network
UNCDF	United Nations Capital Development Fund

ХУРААНГУЙ ҮР ДҮН

54

Санхүүгийн эрүүл мэндийн индекс (FHI)

Санхүүгийн эрүүл мэндийн индекс (FHI) нь 0-100 утгатай үнэлэгдэх бөгөөд Монгол Улсын дундаж үзүүлэлт 54 байна. Энэ нь иргэдийн санхүүгийн эрүүл мэнд дунд түвшинд байгааг харуулж, зарим талбарт сайжруулалт хийх шаардлагатайг илэрхийлж байна.

39

Нөөцийн хүртээмжийн индекс

Санхүүгийн эрүүл мэндийн нэг бүрдэл хэсэг болох нөөцийн хүртээмжийн индекс 39 байна. Энэ нь иргэдийн санхүүгийн гэнэтийн хэрэгцээний үед нөөц бүрдүүлэх чадвар доогуур байгааг харуулж байна. Мөн богино хугацааны санхүүгийн дарамтад өртөх эрсдэлтэй байгааг харуулж байна. Тодруулбал, нэг сар болон нэг долоо хоногийн хугацаанд санхүүгийн нөөц бүрдүүлэхэд хүндрэлтэй иргэдийн хувь өндөр байна.

72

Санхүүгийн хүртээмжийн индекс

Санхүүгийн хүртээмжийн индекс 72 байна. Санхүүгийн үйлчилгээ авах боломж харьцангуй сайн байгаа ч хадгаламжийн түвшин хангалтгүй байна. Судалгаанд оролцогчдын 99 хувь нь банканд данстай боловч тэдний дөнгөж 46 хувь нь хадгаламжтай байгаа нь санхүүгийн сахилга бат, урт хугацааны хуримтлал үүсгэх дадал сул байгааг харуулж байна.

45

Санхүүгийн төлөв байдлын индекс

Санхүүгийн төлөв байдлын индекс 45 байна. Иргэдийн орлогын тогтвортой байдал, эх үүсвэрийн найдвартай байдал харьцангуй доогуур түвшинд байна. Орлогын эх үүсвэрийн тогтвортой байдал хангалтгүй байгаа нь иргэдийн санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлж байна.

53

Санхүүгийн мэдлэгийн индекс

Санхүүгийн мэдлэгийн индекс 53 буюу иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин дундаж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь суурь санхүүгийн ойлголтуудын талаар тодорхой мэдлэгтэй байгаа ч, зарим ойлголт дээр мэдлэг дутмаг байгаа нь илэрхий байна.



59

Санхүүгийн зан төлөвийн индекс

Санхүүгийн зан төлөвийн индекс 59 байна. Иргэдийн санхүүгээ удирдах, төлөвлөх чадвар харьцангуй сайн боловч санхүүгийн хувьд бие даасан байдлын индекс тааруу байгааг онцолж байна.



67

Зээлийн хандлага

62

Зарцуулалтын хандлага

60

Хадгаламжийн хандлага

54

Төлөвлөлтийн хандлага

52

Санхүүгийн хувьд бие даасан байдал



52%

Нийт судалгаанд оролцогчдын 52 хувь нь орлогынхоо зарим хэсгийг ирээдүйдээ зориулж хадгалдаг байна.



70%

Нийт иргэдийн 70 хувь нь санхүүгээ (орлого, зарлага) төлөвлөдөг байна.



39%

Нийт иргэдийн 39 хувь нь тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэдэг байна.



63%

Нийт иргэдийн 63 хувь нь орлогын тогтвортой, найдвартай эх үүсвэртэй иргэд байна.



27%

Нийт иргэдийн 27 хувь нь дор хаяж 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй байна.



48%

Нийт иргэдийн 48 хувь нь хадгаламжид мөнгөө хадгалж байна.



59%

Иргэд, олон нийтийн хувьд санхүүгийн боловсролын талаарх мэдээ, мэдээллийг 59 хувь нь фейсбүүкээс авдаг байна.

I. УДИРТГАЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.13-д ”иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын 2021 оны А-62/63/31/А/26 дугаар тушаалаар ”Монгол Улсын Санхүүгийн Хүртээмжийг Сайжруулах Хөтөлбөр 2021-2025”-ийг баталсан.

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, улмаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих, Тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэх боломж бүрдсэн.

Иймд нийгэм, эдийн засгийн тодорхой нөхцөлд иргэд санхүүгийн чадамжаа үнэлэх, хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээний талаар мэдээлэл олж авах, сонголт хийх, шийдвэр гаргах болон санхүүгийн богино хугацааны хүндрэлийг даван туулах чадвар (санхүүгийн талаарх мэдлэгээ өөрийн санхүүг удирдахад ашиглах), итгэл үнэмшил (санхүүгийн шийдвэр гаргахдаа өөртөө бүрэн итгэлтэй байх) зэрэг олон нийтийн санхүүгийн эрүүл мэндийг хэмжих хэрэгцээ шаардлага үүссэн ба уг суурь судалгааны зөвлөх үйлчилгээний ажлыг судалгаа, зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи компани 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Уг судалгааны ажлын хүрээнд олон улсад судлагдсан байдлын шинжилгээ буюу баримт бичгийн судалгаа болон үндэсний хэмжээнд нийт 850 иргэдийн тоон түүврийн судалгааг зохион байгууллаа. Мэдээлэл цуглуулалтыг судалгааны олон улсын ёс зүйн стандарт болох ESOMAR-ийн ёс зүйн код, нийгмийн болон зах зээлийн судалгааны олон улсын стандарт болох ISO 20252:2019-г баримтлан зохион байгуулсан болно.

II. БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

Санхүүгийн эрүүл мэндийг хэмжих суурь судалгааны хүрээнд асуулга, арга зүйгээ тодорхойлохын тулд олон улсын байгууллагуудаас гаргасан хэд хэдэн судалгааны арга, аргачлалуудыг харьцуулан судалж, судалгааны хэмжих үзүүлэлт, арга зүй, асуулгыг боловсрууллаа. Санхүүгийн эрүүл мэндийг хэмжихийн тулд уг нэр томъёоны нэршил, тодорхойлолт, гол хэмжүүр үзүүлэлтүүдийг судлах шаардлагатай болов. Үүний тулд 7 байгууллагын хүрээнд санхүүгийн эрүүл мэнд гэж юу вэ, үүнийг ямар шалгуур үзүүлэлтүүдээр хэмжих вэ гэдгийг дараах хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн эрүүл мэндийн тодорхойлолтууд¹

№	Байгууллага	Тодорхойлолтын нэршил	Тодорхойлолт
1	Financial Health Network (Өмнө нь CFSI)	Санхүүгийн эрүүл мэнд (АНУ)	Санхүүгийн эрүүл мэндийн 8 индикатор үзүүлэлт: 1. Орлогоосоо бага зарцуулах 2. Төлбөрөө цаг тухайд нь төлөх 3. Хөрвөх чадвартай хангалттай хадгаламж 4. Урт хугацааны хадгаламж 5. Хянах боломжтой зээлийн хэмжээ 6. Анхдагч зээлийн оноо (Prime credit score) 7. Зохистой даатгалд даатгуулах 8. Санхүүгээ урьдчилж төлөвлөх
2	Financial Health Network & Center for Financial Inclusion	Санхүүгийн эрүүл мэнд (Олон Улсад)	Дараах тохиолдолд хувь хүн санхүүгийн хувьд эрүүл байна: 1. Орлого, зарлагаа тэнцвэржүүлдэг 2. Нөөц бүрдүүлж, хадгалдаг 3. Өр төлбөрөө удирдаж, боломжит нөөцийг ашигладаг 4. Санхүүгээ төлөвлөж, эрэмбэлдэг 5. Санхүүгийн гэнэтийн шокийг даван туулдаг 6. Санхүүгийн олон төрлийн үйлчилгээг үр дүнтэй ашигладаг
3	Financial Sector Deepening - FSD Kenya	Санхүүгийн эрүүл мэнд	Судалгаанд оролцогчид дараах шаардлагыг хангаж байвал санхүүгийн хувьд эрүүл гэж үзнэ. 1. Өдөр тутмын санхүүгээ удирдах 2. Эрсдэлтэй дасан зохицох

¹ Lasse Brune, Dean Karlan, Rebecca Rouse, [IPA Financial Health - Full Report Final.pdf \(poverty-action.org\)](#)

			3 . Өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээнд хөрөнгө оруулалт хийх
4	Gallup	Санхүүгийн найдвартай байдал	<p>Судалгаанд оролцогчид дараах 2 нөхцөлийн хоёуланг нь хангасан тохиолдолд санхүүгийн хувьд найдвартай гэж үзнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орлогын эх үүсвэрээ алдсан ч хадгаламж эсвэл худалдах боломжтой зүйлсээрээ амьдрах шаардлагатай болсон тохиолдолд хоол хүнс, орон сууц, унаа гэх мэт БҮХ үндсэн хэрэгцээгээ зургаан сараас дээш хугацаанд хангаж чадна. 2. Өр төлбөрөө барагдуулах үед бусад хэрэгцээний төлбөрөө төлөхөд хүндрэл үүсэхгүй.
5	insight2impact	Санхүүгийн хэрэгцээ	<p>Санхүүгийн хэрэгцээ нь санхүүгийн үйлчилгээг ашиглаж дараах дөрвөн зан үйлдлийг хэрэгжүүлсэн үр дүн юм.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгийн шилжүүлэг 2. Хөрвөх чадвар 3. Тэсвэртэй байдал 4. Зорилгодоо хүрэх
6	Kantar's Financial Inclusion Insights	Санхүүгийн эрүүл мэнд	<p>Та дараах 8 өгүүлбэртэй хэр зэрэг санал нийлж эсвэл нийлэхгүй байна вэ?</p> <ol style="list-style-type: none"> 1. Надад амьдрах зардлаа нөхөх хангалттай мөнгө байгаа 2. Би сар бүр олдог орлогоосоо бага зарцуулалт хийдэг 3. Би өр төлбөрөө бүтнээр нь болон хугацаанд нь төлдөг 4. Төлөвлөгдөөгүй гэнэтийн зардлыг төлөх хангалттай гэнэтийн нөөц надад бий 5. Миний орлого ирээдүйд өснө гэдэгт би итгэлтэй байна 6. Өр төлбөр болон амьдрах зардлаа хангах хангалттай орлогыг би олдог 7. Найз нөхөд болон гэр бүл маань санхүүгийн асуудал тулгарахад намайг тусална гэж найддаг 8. Би өөрийн санхүүгээ сайн удирдах мэдлэг, чадвартай

7	U.S. Consumer financial Protection Bureau	Санхүүгийн сайн сайхан байдал	Тухайн хүн одоогийн болон хэрэгжиж байгаа санхүүгийн шаардлагуудаа бүрэн биелүүлж, ирээдүйн санхүүдээ итгэлтэй байж чадах ба амьдралаас таашаал авах сонголтуудыг хийх боломжтой байхыг хэлнэ.
---	---	-------------------------------	--

Мөн судалгааны арга зүйг тодорхойлохын тулд доорх 3 байгууллагаас бэлтгэсэн тайлангийн арга зүйг судаллаа (Хүснэгт 2).

Хүснэгт 2. “Санхүүгийн эрүүл мэндийг хэмжих суурь судалгаа”-ны олон улсад судлагдсан байдлын жагсаалт

№	Судалгааны ажлын нэр	Хийсэн байгууллагын нэр	Хийгдсэн хугацаа	Хамрах хүрээ	Судалгааны арга зүй, аргачлал	Санхүүгийн эрүүл мэндийн тодорхойлолт, тодорхойлсон гол индикатор үзүүлэлтүүд
1	“Measuring Financial Health around the Globe”	Northwestern University, Innovations for Poverty Action	2020 оны 06 дугаар сард	2018 оны 6 дугаар сараас 2019 оны 2 дугаар сарын хооронд Афганистан, Бангладеш, Колумб, Доминикан, Гана, Перу, Филиппин, Уганда зэрэг 8 оронд шинээр боловсруулсан судалгааны хэрэгслийг ашиглан 11,876 ажиглалт судалгааг цуглуулсан.	Тоон судалгааны аргачлалыг ашигласан	<p>“Financial Health Networking” болон “Center for Financial Inclusion”-аас боловсруулсан ажилд үндэслэж, санхүүгийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг:</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зан байдал • Санхүүгийн хүртээмж • Сангийн/нөөцийн хүртээмж гэсэн 3 үндсэн ангилалд хувааж авч үзсэн.
2	“Delivering Financial Health Globally”	UN Capital Development Fund (UNCDF)	2021 оны 07 дугаар сард	Санхүүгийн эрүүл мэнд, хүртээмжтэй холбоотой 60 гаруй нийтлэл, санхүүгийн салбарын тэргүүлэгч 20 гаруй байгууллагатай ярилцлага хийсэн .	Баримт бичгийн судалгаа болон чанарын судалгааны аргачлалыг ашигласан	Санхүүгийн эрүүл мэнд нь санхүүгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, санхүүгийн хяналт, санхүүгийн эрх чөлөө гэсэн хүний санхүүгийн амьдралын дөрвөн чухал талыг хамардаг. Энэ нь тухайн хүн одоогийн хэрэгцээгээ хангаж, санхүүгийн цочролыг даван туулж, санхүүгийн зорилгодоо хүрэх боломжтой нөхцөл юм. Санхүүгийн эрүүл мэндийг:

						<ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн баталгаа гэдэг нь богино хугацааны амлалтаа биелүүлэх чадвар юм. 2. Санхүүгийн тогтвортой байдал нь гэнэтийн болон таагүй үйл явдлыг даван туулах чадвар юм. 3. Санхүүгийн хяналт гэдэг нь одоо болон ирээдүйд өөрийн санхүүдээ итгэлтэй байх явдал юм. 4. Санхүүгийн эрх чөлөө гэдэг нь санхүүгийн урт хугацааны зорилго, хүслийг биелүүлэх чадвар юм
3	“Beyond Financial Inclusion: Financial Health as a Global Framework”	Center for Financial Services Innovation (CFSI)	2017 оны 03 дугаар сард	<p>Dalberg's Design Impact Group нь 2016 оны 6, 7 дугаар сард санхүүгийн эрүүл мэндийн сонгосон үзүүлэлтүүдийг баталгаажуулах, боловсронгуй болгох зорилгоор Кени, Энэтхэгт чанарын болон тоон судалгаа хийсэн. 2 улсын 18 хот, хөдөөгөөс 89 чанарын ярилцлага хийж, 55 асуулттай тоон судалгаанд 1000 гаруй оролцогчдыг хамруулсан. Үүнээс гадна салбарын гол мэргэжилтнүүдтэй 20 гаруй ярилцлага хийж, дэлхийн санхүүгийн эрүүл мэндийн тогтолцоог хянаж, боловсронгуй болгох зорилгоор хөгжлийн мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачидтай 2 удаа биечлэн уулзалт хийсэн.</p>	<p>Хөгжиж буй дэлхийн санхүүгийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд:</p> <p>Дараах тохиолдолд хувь хүн санхүүгийн хувьд эрүүл байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орлого, зарлагаа тэнцвэржүүлдэг 2. Нөөц бүрдүүлж, хадгалдаг 3. Өр төлбөрөө удирдаж, боломжит нөөцийг ашигладаг 4. Санхүүгээ төлөвлөж, эрэмбэлдэг 	

					<p>5. Санхүүгийн гэнэтийн шокийг даван туулдаг</p> <p>6. Санхүүгийн олон төрлийн үйлчилгээг үр дүнтэй ашигладаг.</p> <p>Хэрэглэгчийн санхүүгийн эрүүл мэндэд түүний дараах зүйлс ихээхэн нөлөөлдөг.</p> <p>1. Абсолют орлогын түвшин</p> <p>2. Орлого, зарлагын тогтворгүй байдал</p> <p>3. Нийгмийн сүлжээ</p> <p>4. Санхүүгийн үүрэг</p>
--	--	--	--	--	--

Эндээс дүгнэж үзэхэд олон улсын ижил төстэй судалгааны тайлан, судалгаанд дурдсанчлан санхүүгийн эрүүл мэнд нь хувь хүний санхүүгийн төлөв байдлыг илэрхийлэх ба энэ нь санхүүгийн хүртээмж, хувь хүний хөрөнгө, эх үүсвэр, нөөцийг бүрдүүлэх, үр дүнтэй удирдах, төлөвлөх, санхүүгийн гэнэтийн нөхцөл байдлыг даван туулах чадварт суурилан хувь хүн хэрхэн хөрөнгөө зарцуулж, хуримтлуулж, зээлж, төлөвлөж байгаа цогц ойлголт юм.

III. СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН

3.1. Санхүүгийн эрүүл мэндийн индекс (Financial Health Index-FHI)

Бид санхүүгийн эрүүл мэнд гэдэг ойлголтыг нөөцийн хүртээмж, санхүүгийн хүртээмж, санхүүгийн зан төлөв, санхүүгийн одоогийн төлөв байдал болон санхүүгийн мэдлэг гэсэн 5 дэд бүлгийн ойлголтуудыг нэгтгэн авч үзэж байна. Эдгээр нь:

1. **Нөөцийн хүртээмж (Access-to-fund):** Иргэдийн санхүүгийн гэнэтийн нөхцөл байдлыг даван туулах нөхцөл байдлыг тодорхойлох, түүнийг бүрдүүлэхэд хүндрэлтэй байх эсэхийг тодруулах;
2. **Санхүүгийн хүртээмж (Access-to-finance):** Иргэдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжтой талаар тодруулах;
3. **Санхүүгийн зан төлөв (Financial behavior):** Иргэдийн хэрхэн хөрөнгөө зарцуулж, хуримтлуулж, зээлж, төлөвлөж байгаа талаар, санхүүгийн хувьд хэр бие даасан эсэхийг тодруулах;
4. **Санхүүгийн төлөв байдал (Financial condition):** Иргэдийн одоогийн санхүүгийн тогтвортой, найдвартай орлогын эх үүсвэртэй эсэхийг тодруулах;
5. **Санхүүгийн мэдлэг (Financial knowledge):** Иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг тодорхойлох зорилготой.

Зураг 1. Санхүүгийн эрүүл мэндийн бүрдэл хэсгүүд



Дээрх ойлголтын хүрээнд бид санхүүгийн эрүүл мэндийг хэмжих гол үзүүлэлтүүдийг тодорхойлон иргэдээс авах түүвэр судалгаагаар тодрууллаа.


Санхүүгийн эрүүл мэндийн индекс (FHI) нь 0-100 гэсэн утгуудын хооронд байрлаж, өндөр байх тусам санхүүгийн эрүүл мэнд сайн байна гэж үнэлэгдэх болно. Санхүүгийн эрүүл мэндийн индексийг дараах байдлаар ангилж байна.

Хүснэгт 3. Санхүүгийн эрүүл мэндийн индексийн ангилал

ҮНЭЛГЭЭ	УТГА	ТАЙЛБАР
(70-100)	Сайн	Иргэдийн санхүүгийн эрүүл мэнд тогтвортой, санхүүгийн мэдлэг, зан төлөв, хүртээмжийн хувьд өндөр үзүүлэлттэй.
(40-69)	Дунд	Санхүүгийн эрүүл мэнд боломжийн түвшинд байгаа боловч зарим талбарт ахиц хэрэгтэй.
(0-39)	Муу	Санхүүгийн эрүүл мэнд сул буюу санхүүгийн бэрхшээлүүд ихтэй байгааг илэрхийлнэ.


Энэхүү ангиллын дагуу Монгол Улсын санхүүгийн эрүүл мэндийн индекс (FHI) нь 54 гэсэн үр дүн гарсан нь иргэдийн санхүүгийн эрүүл мэнд дунд түвшинд хамаарч байгаа бөгөөд цаашид зарим талбарт ахиц хэрэгтэй байгааг илэрхийлж байна. Үүн дотроо нөөцийн хүртээмжийн индекс 39, санхүүгийн хүртээмж 72, санхүүгийн зан төлөв 59, санхүүгийн төлөв байдал 45, санхүүгийн мэдлэгийн хувьд 53 гэсэн индексүүд тус тус гарлаа.

Зураг 2. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, бүрдэл хэсгүүдээр



Санхүүгийн эрүүл мэндийн индексийг бүсээр харвал ялгаатай байгааг харж болно. Тухайлбал, Улаанбаатар хотын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийн индекс хамгийн өндөр буюу 57 гарсан бол зүүн бүсийн иргэдийн хувьд хамгийн бага буюу 48 гэж гарсан байна.

Зураг 3. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, бүсээр



Дэд бүрдэл хэсгүүдээр задлан харвал санхүүгийн мэдлэгийн хувьд баруун бүсийн иргэдийнх 48, зүүн бүсийн иргэдийнх 42 байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага байна. Хангайн бүс болон Улаанбаатар хотын иргэдийн санхүүгийн төлөв байдлын индекс хамгийн өндөр байна. Санхүүгийн хүртээмжийн хувьд бусад дэд бүрдэл хэсгүүдийн индексүүдтэй харьцуулахад дунджаар хамгийн өндөр нь буюу 72 байна. Харин нөөцийн хүртээмжийн хувьд хамгийн бага буюу улсын дүнгээр харахад 39 байгаа бөгөөд бүсээр харвал баруун болон зүүн бүсийн иргэдийн хувьд хамгийн бага гарсан байна.

Хүснэгт 4. Санхүүгийн эрүүл мэндийн индекс, дэд бүрдэл хэсгүүдээр

	Санхүүгийн эрүүл мэндийн индекс	Санхүүгийн зан төлөв	Санхүүгийн мэдлэг	Санхүүгийн төлөв байдал	Санхүүгийн хүртээмж	Нөөцийн хүртээмж
Улсын дүн	54	59	53	45	72	39
Улаанбаатар	57	60	58	48	75	43
Хангайн бүс	52	57	50	48	70	36
Төвийн бүс	51	59	51	40	67	39
Баруун бүс	50	57	48	39	71	32
Зүүн бүс	48	56	42	43	67	33

3.2. Нөөцийн/сангийн хүртээмж (Access-to-funds)

Энэхүү хэсэгт санхүүгийн эрүүл мэндийн нэг дэд бүлэг болох нөөцийн буюу сангийн хүртээмжийн талаар авч үзэх болно.

Нөөцийн хүртээмжийн хувьд бид тухайн хүнд гэнэтийн хэрэгцээнд зориулж мөнгө хэрэгтэй болоход ямар ямар эх үүсвэрүүдээс бүрдүүлэх, түүнийг олоход хэр хэцүү байх талаар асуултуудаар тодруулсан. Эдгээр асуултуудыг Дэлхийн банкны Дэлхийн санхүүгийн хүртээмж² (Global Findex) судалгаанд “Санхүүгийн цочролыг даван туулах, уян хатах байх чадвар” гэж нэрлэдэг. Мөн энэ төрлийн асуулт нь санхүүгийн цочролыг даван туулах чадвараас илүү хувь хүний санхүүгийн байдлыг үнэлэхэд чухал ач холбогдолтой гэж үзсэн учраас санхүүгийн эрүүл мэндийн нэг гол үзүүлэлт болгож авлаа.

Уг судалгааны суурь аргачлал болгож авсан судалгаанд нийт 8 улс орны иргэдийг хамруулсан байсан. Эдгээр улсыг хооронд нь харьцуулахын тулд жишиг мөнгөн дүн болгож тухайн улс орны нэг хүнд ногдох ҮНБ-ийн 1/20-ийг дотоодын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг нэг долоо хоногийн дотор, мөн нэг сарын хугацаанд бүрдүүлэхэд хэр хэцүү байх талаар оролцогчдоос асуулаа. Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНБ-ийн 1/20-ийг дотоодын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн дүн нь 895,170 төгрөг бөгөөд ойролцоогоор 895,000 төгрөг³ гэж тоймлож асуулаа.

Эхлээд судалгаанд оролцогчдоос нэг сарын дотор 895,000 төгрөгийг олох шаардлага гарвал ямар эх үүсвэрүүдээс бүрдүүлэхийг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 44 хувь нь цалингаас бүрдүүлэх, 41 хувь нь гэр бүл, найз нөхдөөс тусламж, зээл авах, мөн 41 хувь нь бусад эх үүсвэрээс зээл авна, 26 хувь нь хуримтлалаас төлнө гэж хариулжээ.

² World Bank's Global Financial Inclusion (Global Findex) survey


³ Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНБ-ийн 1/20-ийг дотоодын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн дүн: 895,170 төгрөгийг ойролцоолсон дүн = 895,000 төгрөг

Зураг 4. 1 сарын дотор 895,000 төгрөг олох санхүүгийн эх үүсвэр



Судалгаанд оролцогчдоос 895,000 төгрөгийг нэг сар болон нэг долоо хоногийн дотор олоход хэр хэцүү байх талаар дараах графикт харуулж байна. Үүнээс харахад нийт оролцогчдын 43 хувь нь 1 долоо хоногийн дотор олоход маш хэцүү гэж хариулсан бол 1 сарын дотор олоход 22 хувь нь маш хэцүү гэжээ. Уг хариултын хувьд (-21) хувийн зөрүүтэй байгаа нь санхүүгийн гэнэтийн хэрэгцээ үүсэхэд иргэдэд үүсэж буй санхүүгийн дарамт цаг хугацаанаас хамааран ялгаатай байдал үүсэж байгаа нь харагдаж байна. Дээрх мөнгийг бүрдүүлэхэд огт хэцүү биш гэж хариулсан байдлыг харвал, судалгаанд оролцогчдын 8 хувь нь 1 долоо хоногийн дотор олоход огт хэцүү биш гэсэн бол 1 сарын дотор олоход энэ хувь нэмэгдэж 14 хувьтай хариулсан байна.

Зураг 5. 895,000 төгрөгийг 1 сар болон 1 долоо хоногийн дотор олоход хэр хэцүү байх байдал



Үүнийг хүн амзүйн үзүүлэлтээр задлан харахад уг мөнгийг 1 сарын дотор олоход хэр хэцүү байх байдал харьцангуй ялгаагаагүй байгаа харагдаж байна. Харин 1 долоо хоногийн дотор олоход ялгаатай үр дүнгүүд гарсан байна. Насны бүлгээр харвал насны бүлэг ахих тусам маш хэцүү гэсэн хувь буурч байна. Боловсролын түвшин дээшлэх тусам мөн адил бага болж байна. Бүсээр харвал баруун болон зүүн бүсийн хувьд маш хэцүү гэсэн хувь өндөр байна. Ажил эрхлэлтийн хувьд оюутан сурагч, ажил эрхлэхгүй байгаа, гэртээ хүүхдээ хардаг, төрийн байгууллагад ажилладаг иргэдийн хувьд 1 долоо хоногийн дотор олоход маш хэцүү байдал өндөр байна.

3.3. Санхүүгийн хүртээмж (Access-to-finance)


Энэ бүлэгт иргэдийн санхүүгийн хүртээмжийн талаар дурдана. Бид санхүүгийн эрүүл мэнд гэдэг ойлголтын нэг хэсгийг санхүүгийн хүртээмж гэж авч үзсэн бөгөөд үүнийг цөөн хэдэн асуултаар тодрууллаа.

Ерөнхийдөө Монгол Улсын иргэдийн хувьд харьцангуй нийтээрээ банканд данстай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 99 хувь нь банканд данстай байна. Харин 46 хувь нь хадгаламжтай гэж хариулсан ба бүсээр задлан харвал Улаанбаатар хотын иргэдийн 2 хүн тутмын 1 нь хадгаламжтай байна. Мөн хангайн бүсийн иргэд бусад бүсүүдийн иргэдтэй харьцуулахад илүү их хадгалдаг байна.

Зураг 6. Банканд данстай эсэх




Зураг 7. Хадгаламжтай эсэх



Банканд дансгүй гэж хариулсан иргэдээс яагаад дансгүй байгаа талаар тодруулахад, 37 хувь нь надад санхүүгийн байгууллагын үйлчилгээг ашиглах хангалттай мөнгө байхгүй, 32 хувь нь надад шаардлагатай бичиг баримт байхгүй (иргэний үнэмлэх гэх мэт) гэсэн шалтгаануудтай байна.

Зураг 8. Банканд дансгүй байгаа шалтгаанууд, n=12



Мөн төлбөр тооцоо хийхдээ ихэвчлэн ашигладаг хэрэгсэл нь ихэвчлэн гар утсаар банкны аппликейшн ашигладаг, банкны картаар, гар утасны аппликейшнд суурилсан аппууд ашигладаг гэж хариулжээ.

Зураг 9. Төлбөр тооцоо хийхдээ тогтмол ашигладаг хэрэгсэл



Хэрэв мөнгө зээлэх тохиолдол гарвал хаанаас, ямар хэлбэрээр зээлэх талаар тодруулахад нийт оролцогчдын 51 хувь нь буюу 2 хүн тутмын 1 нь хамгийн түрүүнд гэр бүл, найз нөхдөөс зээл авна гэсэн бол үүний дараагаар банкнаас онлайнаар зээлнэ, ББСБ-аас онлайнаар зээл авна гэж тус тус хариулсан байна.

Зураг 10. Мөнгө зээлэх эх үүсвэр, хэлбэрээр



3.4. Санхүүгийн зан төлөв (Financial behavior)

Энэ бүлэгт иргэдийн санхүүгийн зан төлөв, санхүүгээ хэрхэн удирдаж, ирээдүйгээ төлөвлөдөг, шийдвэр гаргалтын талаар дэлгэрэнгүй авч үзэх болно. Ингэхдээ санхүүгийн зан төлөвийг дараах дэд хэсгүүдэд задалж авлаа. Үүнд:


1. Зээлийн хандлага
2. Мөнгөө хадгалах хандлага
3. Мөнгөө хэрхэн төлөвлөж буй хандлага
4. Зарцуулалтын хандлага
5. Санхүүгийн хувьд бие даасан байдал гэсэн нийт таван дэд хэсгүүдээс бүрдэж байна.

1.4.1 Зээлийн хандлага

Энэ хэсэгт зээлийн хандлагын талаар дурдана. Ингэхдээ нийт оролцогчдоос зээлийн хандлагын 6 үзүүлэлтийн хүрээнд хэр зэрэг санал нийлж байгаа талаар (1-5) онооны хооронд хариултыг авч дараах үр дүн гарсан байна.

“Би мөнгө зээлэх эсвэл зээлээр худалдан авалт хийхдээ болгоомжтой ханддаг” гэсэн үзүүлэлтийн хувьд нийт оролцогчдын 47 хувь нь маш их санал нийлж байна гэж хариулсан байна. Энэ нь 2 хүн тутмын 1 нь мөнгө зээлэхдээ, зээлээр ямар нэгэн худалдан авалт хийхээсээ өмнө маш няхуур хандаж, хэрэгцээтэй эсэхийг нягталсны үндсэн дээр шийдвэр гаргадаг гэдэг нь харагдаж байна.


Зураг 11. Зээлийн хандлагын үзүүлэлтүүд



1.4.2 Мөнгөө хадгалах хандлага

Уг бүлэгт иргэдийн мөнгөө хадгалах зан төлөв, хандлагын талаар авч үзнэ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 52 хувь нь орлогынхоо зарим хэсгийг ирээдүйдээ зориулж, хадгалдаг байна. Үүнийг хүн амзүйгээр харвал эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд нь түлхүү хадгалдаг байна. Мөн 18-23 насны залуучуудын хувьд өндөр байгаа бол нас ахих тусам хадгалах хандлага буурч байна. Сууцны төрлөөр орон сууцанд амьдардаг иргэд, бүсээр гэвэл Улаанбаатар хотод амьдардаг иргэдийн хувьд бусад бүлгийн хүмүүстэй харьцуулахад өндөр харагдаж байна.


Зураг 12. Орлогынхоо зарим хэсгийг ирээдүйдээ зориулж хадгалдаг байдал



Өнгөрсөн 1 жилийн хугацаанд өрхийн орлого, зарлагаа хэрхэн тодорхойлох вэ гэдгийг тодруулахад 42 хувь нь орлоготойгоо тэнцүү зарцуулдаг гэж хариулсан байна. Ерөнхийд нь харвал орлогоосоо их зарцуулсан байдал бага зарцуулсан хариултаас 11 хувиар өндөр

(Орлогоосоо их 35%-Орлогоосоо бага 24%) байгаа нь өрхийн хэрэглээний зардал, олж буй орлогын хэмжээнээс давсан, орлого нь өрхийн хэрэглээний зардалд хүрэлцдэггүй байх талтай байна.

Зураг 13. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд өрхийн орлого, зарлагаа тодорхойлох байдал



Хэрвээ орлогоосоо их зарцуулсан бол уг зөрүүгээ хэрхэн нөхсөн талаар асуухад 35 хувь нь гэр бүл, найз нөхдөөс зээл авсан, 28 хувь нь банкнаас онлайнаар зээлсэн, 24 хувь нь ББСБ-аас онлайнаар зээл авсан, 17 хувь нь ломбардаас зээл авсан, 14 хувь нь хадгаламжаа ашигласан гэж тус тус хариулжээ. Эндээс харахад өрхийн зарцуулалт, орлогоосоо давах үед ямар нэгэн байдлаар зээл авч хэрэглээгээ нөхдөг байдал өндөр байгааг харуулж байна.


Зураг 14. Орлогоосоо их зарцуулсан зөрүүгээ нөхсөн байдал



Иргэдийн мөнгөө хадгалах хандлагыг ойлгохын тулд нийт 3 үзүүлэлтийг мөн адил (1-5) онооны хооронд хэр зэрэг санал нийлж байгаа талаар тодруулсан.

“Би ирээдүйд зориулж мөнгө хадгалахыг хичээдэг.” гэсэн үзүүлэлтийн хувьд нийт оролцогчдын 44 хувь нь маш их санал нийлж байна гэж хариулсан буюу 2 хүн тутмын 1 нь ирээдүйд зориулж мөнгө хадгалахыг эрмэлздэг байна.


Зураг 15. Мөнгөө хадгалах хандлагын үзүүлэлтүүд



1.4.3 Мөнгөө төлөвлөх хандлага


Санхүүгийн зан төлөвийн нэг хэсэг болох мөнгөө хэрхэн төлөвлөдөг талаар энэ бүлэгт тайлбарлан бичлээ. Иргэдийн санхүүгээ буюу орлого, зарлагаа төлөвлөдөг байдал харьцангуй өндөр байна. Тухайлбал, нийт судалгаанд хамрагдсан оролцогчдын 70 хувь нь буюу 10 хүн тутмын 7 нь санхүүгээ хэрхэн зарцуулахаа төлөвлөдөг байна. Хүн амзүйн үзүүлэлтээр задлан харвал түлхүү эмэгтэйчүүд, 46-54 насныхан, хангайн бүсийн иргэд, орон сууцанд амьдардаг, гэрлэсэн хүмүүс, магистр, доктор, бакалавр зэрэгтэй иргэд санхүүгээ төлөвлөж байна. Ялангуяа хувийн орлого нэмэгдэх тусам санхүүгээ төлөвлөдөг хандлага өндөр байгаа харагдаж байна.

Зураг 16. Санхүүгээ (орлого, зарлага) төлөвлөдөг байдал




Санхүүгээ төлөвлөж буй хугацааг харвал дийлэнх нь богино хугацаанд төлөвлөдөг буюу нийт оролцогчдын 35 хувь нь 7 хоногоос 1 сар хүртэл, 24 хувь нь 1 сараас 3 сар хүртэлх хугацаагаар төлөвлөдөг гэж хариулжээ.

Зураг 17. Санхүүгээ төлөвлөж буй хугацаа



Мөн оролцогч нараас тэтгэвэрт гарахдаа зориулж төрөл бүрийн хуримтлал үүсгэн түүнийг хэрхэн цуглуулах талаар төлөвлөгөө байгаа эсэхийг тодруулахад 39 хувь нь тийм гэж хариулжээ.

Зураг 18. Тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэдэг эсэх



Үүнийг хүн амзүйн үзүүлэлтээр харвал хүйсийн хувьд ялгаагүй ижилхэн байна. 18-23 насны залуучуудын 10 хүн тутмын 4 нь тэтгэвэртээ зориулж хадгалдаг байна. Бүсээр харвал Улаанбаатар хотын иргэд, гэрлэлтээ албан ёсоор батлуулсан хүмүүс, мөн адил хувийн орлого нэмэгдэх тусам тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэдэг байдал нэмэгдэж байна.


1.4.4 Зарцуулалтын хандлага

Санхүүгийн зан төлөвийн бас нэгэн хэсэг болох зарцуулалтын хандлагыг нийт 3 үзүүлэлтийн хүрээнд тодрууллаа.

“Би төлөх ёстой тогтмол төлбөрүүдээ цаг тухайд нь бүрэн төлдөг. (Үүнд, түрээс, сургуулийн төлбөр, ус цахилгаан төлбөр, түлш гэх мэт)” гэсэн үзүүлэлтийн хувьд нийт оролцогчдын 62

хувь нь маш их санал нийлж байна гэж хариулсан байна. Энэ нь 10 хүн тутмын 6 нь өрхийн хэрэглээний зардал, бусад тогтмол гардаг зардлуудаа цаг хугацаанд нь хийдэг байна.

Зураг 19. Зарцуулалтын хандлагын үзүүлэлтүүд




1.4.5 Санхүүгийн хувьд бие даасан байдал

Энэ хэсэгт тухайн хүний санхүүгийн хувьд хэр бие даасан байдлын талаар асуусан. Ингэхдээ нийт 7 үзүүлэлтийн дагуу хэр зэрэг санал нийлж байгаа талаар тодрууллаа.

“Би 895,000 төгрөгийг бусдын зөвшөөрөлгүйгээр хэрхэн зарцуулахаа ихэвчлэн өөрөө шийддэг.” гэсэн үзүүлэлтийн хувьд нийт оролцогчдын 40 хувь нь маш их санал нийлж байна гэж хариулсан байна. Харин 895,000 төгрөгийг бусдын зөвшөөрөлгүйгээр хэрхэн зарцуулахаа ихэвчлэн өөрөө шийддэггүй, хүнтэй харилцан, зөвшилцсөний үндсэн дээр шийддэг бүлгийг хүн амзүйн үзүүлэлтээр задлан харвал 18-23 насны залуучууд, гэрлэлтээ батлуулсан болон хамтран амьдарч байгаа иргэд, оюутан, сурагчид, баруун бүсийн аймгийн иргэд байна. Мөн хувийн орлого нэмэгдэх тусам 895,000 төгрөгийг хэрхэн зарцуулахаа өөрөө шийддэг хандлага нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна.


Зураг 20. Санхүүгийн хувьд бие даасан байдлын талаарх үзүүлэлтүүд



3.5. Санхүүгийн төлөв байдал

Нийт судалгаанд оролцсон иргэдийн 63 хувь нь орлогын тогтвортой, найдвартай эх үүсвэртэй гэж хариулсан байна. Үүнийг хүн амзүйгээр задлан харвал нас ахих тусам орлогын хувьд тогтвортой болж байгаа бөгөөд харин 18-23 насны залуучуудын хувьд ихэвчлэн оюутан, сурагчид байгаа тул орлогын найдвартай, тогтвортой эх үүсвэртэй болж хараахан амжаагүй байна. Байршлын хувьд Улаанбаатар хот болон хангайн бүсийн иргэд бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр хувьтай байгаа нь харагдаж байна. Ажил эрхлэлтээр харвал хувийн болон төрийн байгууллагад ажилладаг иргэдийн 74 хувь нь тогтвортой орлоготой гэжээ. Харин хувиараа бизнес эрхлэгч, төрийн бус болон олон улсын байгууллагад ажилладаг иргэдийн хувьд бага зэрэг тогтворгүй байна. Орлогын хувьд тогтворгүй, бусдаас хамааралтай байдаг иргэдийг харвал ажил эрхлэхгүй байгаа, гэртээ хүүхдээ хардаг иргэд, оюутан сурагчид байна. Мөн хувийн орлого нэмэгдэх тусам орлогын хувьд тогтвортой, найдвартай болж ирж байна.

Зураг 21. Орлогын тогтвортой, найдвартай эх үүсвэртэй эсэх



Өрхийн орлогын сар бүрийн өөрчлөлтийг хэр зэрэг хэлбэлзэлтэй байдаг талаар мөн тодрууллаа. График 25-д харуулж байгаачлан нийт иргэдийн 34 хувь нь өрхийн орлого нь сар бүр ижил байдаг гэсэн байна. Эндээс харахад нийт иргэдийн ердөө 30 гаруй хувь нь өрхийн орлогын хувьд тогтвортой байдаг бол үлдсэн 66 хувь нь ямар нэгэн байдлаар тогтвортой бус, хэлбэлзэж байдаг байна. Өөрчлөлтийн хувьд харвал ихэвчлэн сар бүр бага зэрэг өөрчлөгддөг эсвэл зарим сар маш бага, заримдаа маш өндөр байдаг байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 5 хувь нь сар бүрийн өрхийн орлогоо тодорхойлж мэдэхгүй байна.

Зураг 22. Өрхийн орлогын сар бүрийн өөрчлөлтийг тодорхойлж буй байдал




Өрхийн орлогын сар бүрийн өөрчлөлтийг тодорхойлохоос гадна ирэх сарын өрхийн орлогын хэмжээг хэрхэн таамаглаж чадаж буй талаар иргэдээс тодрууллаа. Нийт судалгаанд оролцсон иргэдийн 9 хувь нь ирэх сарын өрхийн орлогын хэмжээг таамаглахад маш хэцүү, 43 хувь нь бага зэрэг хэцүү, 39 хувь нь огт хэцүү биш, 9 хувь нь хэлж мэдэхгүй байна гэж тус тус хариулжээ. Эндээс харахад 39 хувь нь таамаглахад огт хэцүү биш гэж хариулсан байгаа нь иргэдийн 10 хүн тутмын 4 хүний өрхийн орлогын хэмжээ тогтвортой байна гэж харагдаж байна.

Зураг 23. Ирэх сарын өрхийн орлогын хэмжээг таамаглаж чадаж буй байдал



Түүнчлэн судалгаанд оролцогчдоос танд дор хаяж 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй эсэхийг тодруулахад 27 хувь нь тийм гэж хариулжээ. Үүнийг хүн амзүйн үзүүлэлтээр хэр ялгаатай байгаа эсэхийг харахад нас ахих тусам 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй гэж хариулах байдал нэмэгдэж байна. Ажил эрхлэлтийн хувьд оюутан, сурагчид, ажил эрхлэхгүй байгаа, гэртээ хүүхдээ хардаг иргэдийн хувьд хамгийн бага байна. Мөн адил хувийн орлого дээшлэх тусам 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй байх байдал нэмэгдэж байна.

Зураг 24. Дор хаяж 3-6 сарын амьжиргааны зардлыг нөхөх хангалттай нөөцтэй эсэх



Иргэдийн санхүүгийн одоогийн төлөв байдлыг тодруулах ойлголтын хүрээнд хөрөнгө оруулалт хийж буй төрлүүдийг асуулаа. Хөрөнгө оруулалт хийж буй иргэдийн хувьд дийлэнх нь эрсдэл багатай хөрөнгө оруулалтын төрлүүдийг сонгож байна. Тухайлбал, нийт судалгаанд оролцогчдын 48 хувь нь буюу 2 хүн тутмын 1 нь хадгаламжид мөнгөө хадгалдаг байна. Түүний дараагаар нийт иргэдийн 34 хувь нь үл хөдлөх хөрөнгөд, 23 хувь нь хувьцаа, 23 хувь нь газар, 17 хувь нь үнэт эдлэл зэрэгт хөрөнгө оруулалт хийдэг байна. Криптовалют буюу койн, бонд, үнэт цаас зэрэгт хөрөнгө оруулалт хийх байдал бага байна.

Зураг 25. Хөрөнгө оруулалт хийж буй хэлбэрүүд




3.6. Санхүүгийн мэдлэг

1.6.1 Санхүүгийн боловсрол авах суваг

Иргэд, олон нийтийн хувьд санхүүгийн боловсрол авах мэдээ, мэдээллийг цахим сүлжээнээс авах байдал хамгийн өндөр буюу 59 хувь нь фейсбүүкээс авдаг байна. Тиймээс иргэд, олон нийтэд санхүүгийн боловсролын талаар мэдээлэл өгөхдөө олон нийтийн цахим сүлжээг түлхүү ашиглах нь зүйтэй харагдаж байна. Мөн түүнчлэн 33 хувь нь телевизээс, 31 хувь нь гэр бүлийн гишүүдээс, 28 хувь нь найз нөхөд, танилаасаа, 23 нь ном, сонин, сэтгүүл гэх мэт сувгуудаас мэдээ, мэдээлэл авдаг гэжээ.

Зураг 26. Санхүүгийн боловсрол авах суваг




Фейсбүүкийн хувьд 18-28 насны иргэд мэдээлэл авах байдал өндөр байгаа тул энэ насны бүлэгт санхүүгийн боловсролын талаар мэдээлэл өгөхдөө фейсбүүк пост, богино рийлс хэлбэрээр байвал зүйтэй. Нас нэмэгдэх тусам фейсбүүкээс мэдээлэл авах байдал буурч байна. Харин телевизийн хувьд нас нэмэгдэх тусам мэдээлэл авах байдал нэмэгдэж байна.

1.6.2 Санхүүгийн мэдлэг

Энэ хүрээнд санхүүгийн мэдлэг хэсгийг үнэлэхдээ санхүү болон эдийн засгийн суурь ойлголт, мэдлэгийг шалгах 8 асуултыг оролцогчдоос асуусан. Нийт оролцогчдын 19 хувь нь (0-2) асуултад, 33 хувь нь (3-4) асуултад, 37 хувь нь (5-6) асуултад, 11 хувь нь (7-8) асуултад зөв хариулсан байна.

Зураг 27. Санхүүгийн мэдлэгийн талаарх асуултуудад зөв хариулсан байдал



Санхүүгийн мэдлэгийн асуултуудыг харьцуулж харвал хадгаламжийн талаар асуулт хамгийн өндөр зөв хариулттай буюу 81 хувь, хөрөнгө оруулалт болон эрсдэлийн талаарх асуулт хамгийн бага зөв хариулттай буюу 30 хувь байна. Мөн мөнгөний худалдан авах чадварт инфляц нөлөөлөх тухай асуултад судалгаанд оролцогчдын 72 хувь, өрхийн төсвийн асуултад 59 хувь, мөнгөний хүүгийн талаар асуултад 53 хувь, зээлийн талаарх асуултад 48 хувь, инфляцын талаар 47 хувь, даатгалын асуултад 37 хувь нь тус тус зөв хариулсан байна (Хүснэгт 18).

Хүснэгт 5. Санхүүгийн мэдлэгийн асуултуудад зөв хариулсан байдал


Санхүүгийн мэдлэгийг тодорхойлох асуултууд	Зөв хариулт (%)
Хадгаламжийн талаар	81%
Инфляц нэмэгдэхийн хэрээр мөнгөний худалдан авах чадвар буурна	72%
Өрхийн төсвийн талаар	59%
Мөнгөний хүүгийн талаар	53%
Зээлийн талаар	48%
Инфляцын талаар	47%
Даатгалын талаар	37%
Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн талаар	30%

Дээрхээс харахад манай улсын иргэдийн санхүүгийн мэдлэг хангалтгүй байгаа тул олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Иргэдэд санхүүгийн боловсрол олгоно гэдэг нь иргэн өөрийн нөхцөл байдалд тохируулан санхүүгийн зөв зохистой шийдвэр гаргах, арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг хэлнэ.

3.7. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд 18-64 насны 850 хүн хамрагдсан бөгөөд үүний 22 хувь нь 29-35 настай, 55 хувь нь эмэгтэй, 55 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Дунджаар 36 настай, өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

Зураг 28. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл



IV. ДҮГНЭЛТ

Суурь нөхцөл байдал

Судалгааны үр дүнд Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэнд дунд түвшинд байгаа нь тодорхой харагдаж байна. Санхүүгийн эрүүл мэндийн индекс 54 байгаа нь иргэдийн санхүүгийн нөхцөл байдал тогтворгүй, санхүүгийн мэдлэг, нөөц бүрдүүлэх чадвар дунд түвшинд байгааг харуулж байна.

Судалгаанд тусгасан таван үндсэн үзүүлэлтийн дагуу дараах дүгнэлтийг боловсрууллаа.

- Нөөцийн хүртээмж:** Санхүүгийн эрүүл мэндийн нэг дэд үзүүлэлт болох нөөцийн хүртээмжийн индекс улсын дүнгээр харахад 39 буюу бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн бага байна. Энэ нь нийт иргэдийн хувьд санхүүгийн нөөц бүрдүүлэх, гэнэтийн хэрэгцээнд бэлэн байх чадвар сул байгааг харуулж байна. Үүнийг бүсээр задлан харвал баруун болон зүүн бүсийн иргэдийн хувьд хамгийн бага гарсан нь эдгээр бүсийн иргэд санхүүгийн цочролыг даван туулах, уян хатан байх чадвар сул байгааг илэрхийлж байна. Иргэдийн хувьд гэнэтийн хэрэгцээнд зориулж мөнгө хэрэг болоход дийлэнх нь цалингийн орлогоос бүрдүүлэх, гэр бүл, найз нөхдөөс тусламж авах, зээл авах, хуримтлалаас төлөх хандлагатай байна. Үүнийг хүн амзүйгээр ялгаатай эсэхийг харахад оюутан, сурагч нарын хувьд гэр бүл, найз нөхдөөс тусламж, зээлээр бүрдүүлэх, харин ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд цалин болон хуримтлалаас бүрдүүлэх гэсэн бол нас ахих тусам зээлэх хандлага нэмэгдэж байна. Мөн санхүүгийн гэнэтийн хэрэгцээ үүсэхэд иргэдэд үүсэж буй санхүүгийн дарамт цаг хугацаанаас хамааран ялгаатай байгаа нь харагдаж байсан. Тиймээс цаашид улсын хэмжээнд иргэдэд санхүүгийн сахилга бат, хэмнэлт, хуримтлал үүсгэх хандлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Санхүүгийн хүртээмж:** Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлт нь иргэдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжийг илэрхийлж байгаа бөгөөд уг индекс нь улсын дундаж дүнгээр 72 гэж гарсан нь бусад дэд үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн өндөр нь байна. Үүнийг хэмжихдээ судалгаанд оролцогчдын банканд данстай эсэх болон хадгаламж эзэмшлийн хувь хэмжээгээр гаргасан бөгөөд бараг бүх оролцогч данстай байсан (99%) хэдий ч хадгаламжийн түвшин (46%) хангалтгүй байна. Байршлаар харвал Улаанбаатар хот болон хангайн бүсийн иргэд бусад бүсийн иргэдтэй харьцуулахад илүү их хадгалдаг байна. Эндээс харахад санхүүгийн үйлчилгээнд хандах боломж сайн байгаа ч иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын талаарх ойлголт, дадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.
- Санхүүгийн зан төлөв:** Энэ хэсгийг авч үзэхдээ иргэдийн зээлэх, мөнгөө хадгалах, мөнгөө хэрхэн төлөвлөж буй байдал, зарцуулалтын хандлага, санхүүгийн хувьд бие даасан байдал гэсэн таван дэд хэсгүүдээс авч үзсэн. Үр дүнд нь нийт индекс нь 59 гарсан байна. Үүн дотроо хамгийн өндөр нь зээлийн хандлагын индекс 67, зарцуулалтын хандлага 62, мөнгөө хадгалах хандлага 60, төлөвлөлтийн хандлага 55, санхүүгийн хувьд бие даасан байдлын индекс 52 гэж тус тус гарлаа. Ялангуяа, иргэдийн урт хугацааны санхүүгийн төлөвлөлт болон санхүүгийн хувьд бие даасан

- байдал хангалтгүй байна. Улаанбаатар хотын иргэдийн хувьд улсын дундаж дүнгээс 1 оноогоор өндөр байна.
4. **Санхүүгийн төлөв байдал:** Иргэдийн санхүүгийн тогтвортой, найдвартай эх үүсвэртэй эсэхийг тодруулж, одоогийн санхүүгийн төлөв байдлыг тодорхойлоход 45 гэж байгаа нь иргэдийн орлогын тогтвортой байдал болон эх үүсвэрийн найдвартай байдал сул байгааг илтгэж байна. Байршлаар харвал хангайн бүс болон Улаанбаатар хотын иргэдийн санхүүгийн төлөв байдлын индекс хамгийн өндөр байгаа буюу бусад бүсийн иргэдтэй харьцуулахад харьцангуй тогтвортой, найдвартай санхүүгийн эх үүсвэртэй байгаа нь харагдаж байна. Харин баруун бүсийн иргэдийн хувьд хамгийн бага байна. Хүн амзүйн үзүүлэлтээр харвал нас ахих тусам орлогын хувьд тогтвортой болж байна. Ажил эрхлэлтийн хувьд хувийн болон төрийн байгууллагад ажилладаг 10 хүн тутмын 7 нь тогтвортой орлоготой гэжээ. Орлогын хувьд тогтворгүй, бусдаас хамааралтай байдаг иргэдийг харвал ажил эрхэлдэггүй, гэртээ хүүхдээ хардаг, оюутан, сурагчид байна. Мөн хувийн орлого нэмэгдэх тусам орлогын хувьд тогтвортой, найдвартай болж ирж байна.
 5. **Санхүүгийн мэдлэг:** Санхүүгийн мэдлэгийн индекс улсын дүнгээр 53 байгаа нь иргэдийн санхүүгийн мэдлэг дундаж түвшинд байгааг харуулж байна. Бүсээр харвал баруун бүсийн иргэдийнх 48, зүүн бүсийн иргэдийнх 42 байгаа нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн бага байна. Дээрхээс харахад манай улсын иргэдийн санхүүгийн мэдлэг хангалтгүй байгаа тул олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Ингэхдээ санхүүгийн боловсролын талаарх мэдээлэл авах сувгийг харвал цахим сүлжээнээс авах байдал хамгийн өндөр буюу 59 хувь нь фейсбүүкээс авч байгаа тул иргэд, олон нийтэд санхүүгийн талаар мэдээлэл өгөхдөө олон нийтийн цахим сүлжээг түлхүү ашиглах нь зүйтэй байна. Иргэдэд санхүүгийн боловсрол олгоно гэдэг нь иргэн өөрийн нөхцөл байдалд тохируулан санхүүгийн зөв зохистой шийдвэр гаргах, арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг хэлнэ.
 6. Эдгээр дүгнэлтүүдээс харахад, Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийн түвшнийг дээшлүүлэхийн тулд санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хуримтлал үүсгэх дадлыг төлөвшүүлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн санхүүгийн нөөц бүрдүүлэхэд анхаарах, санхүүгийн бодлогоор дэмжих замаар иргэдийн санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

V. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны дүнгээс харахад Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийг сайжруулахын тулд дараах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн эрүүл мэндийг сайжруулах ажлын хүрээнд:



Судалгааны үр дүнгээс харахад нэн тэргүүнд Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийг сайжруулахын тулд дараах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Санхүүгийн нөөц бүрдүүлэх чадварыг сайжруулах:** Иргэдийн гэнэтийн санхүүгийн хэрэгцээ үүсэх үед нөөц бүрдүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хуримтлал үүсгэх дадлыг төлөвшүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд:
 - Хуримтлал үүсгэх урамшууллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
 - Банк болон санхүүгийн байгууллагуудтай хамтран урт хугацааны хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийг санал болгох
 - Иргэдэд хуримтлалын ач холбогдлыг сурталчлах, мэдээллийн кампанит ажил өрнүүлэх
- Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх:** Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зорилтот сургалт, мэдээлэл олгох ажлуудыг өргөн цар хүрээнд зохион байгуулах хэрэгтэй. Үүнд:
 - Ерөнхий боловсролын сургуулиудад санхүүгийн суурь мэдлэг олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх
 - Насанд хүрэгчдийн санхүүгийн сургалт, семинар зохион байгуулж, санхүүгийн удирдлага, төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах
 - Орон нутгийн болон бүс нутгийн онцлогт тохирсон сургалтын материал, контентыг хөгжүүлэх
- Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх:** Санхүүгийн дэд бүтцийн сайжруулалт, зайнаас үйлчилдэг банкны аппликейшн болон онлайн үйлчилгээний хөгжүүлэлтэд анхаарах хэрэгтэй. Мөн орон нутагт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор, банк болон ББСБ-уудыг орон нутагт илүү өргөн цар хүрээнд үйлчилгээ үзүүлэхийг дэмжих нь зүйтэй.

Эдгээр санал, зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, хуримтлал үүсгэх дадлыг төлөвшүүлэх, санхүүгийн нөөц бүрдүүлэх чадварыг сайжруулах боломжтой бөгөөд Монгол Улсын санхүүгийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд томоохон ахиц гарна гэж үзэж байна.